# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 12 сарын 18 өдөр Дугаар 13 Сүхбаатар сум

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн
төлөвлөгөөний хэрэгжилтийн дүнгийн тухай

Төсвийн тухай хуулийн 69.3, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "*Дотоод аудитын дүрэм*"-ийн 7.7, Сангийн Сайдын 2019 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "*Дотоод аудитын хорооны дүрэм*"-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан *Санхүүгийн хяналт дотоод аудитын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"*-г 3 бүлэг, 39 арга хэмжээтэйгээр боловсруулан, батлуулж, хэрэгжилтийг тайлагнахад бүрэн хэрэгжсэн 38, дутуу хэрэгжсэн 1, дундаж үнэлгээ 99.5% хувьтай тайлагнаж салбарын сургалтууд сайн зохион байгуулж, шилэн дансны мэдээлэлд хяналт тавьж үр дүнг дээшлүүлэн ажилласан байдлыг дүгнэн үзээд Санхүүгийн хяналт аудитын албаны 2024 оны үйл ажиллагааг "Маш сайн" гэж дүгнэсүгэй.

Хоёр. Дараагийн хуралдаанаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээний байгууллагуудад мөрдөх Эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах заавар аргачлалын журмын төсөл, Санхүүгийн хяналт дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөө, 2025 онд санхүүгийн хяналт, дотоод аудитад хамрагдах байгууллагуудыг эрсдэлийн үнэлгээнд суурилсан төлөвлөгөөг боловсруулан танилцуулахыг албаны дарга (Т.Одсүрэн)-д даалгасугай.

Хоёр. Дотоод аудитын хорооны тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нарийн бичгийн дарга (Т.Мөнхзул)-д үүрэг болгосугай.

Хорооны дарга: Н.Лхагвадорж
(Аймгийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Т.Мөнхзул
(Ахлах дотоод аудитор)

МНДА0005 9055053

Гишүүд: Т.Одсүрэн
(Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга)

Ө.Сувдаа
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

4324009013

Х.Мөнхжаргал
(Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга)

Б.Янжинлхам
(Хууль зүйн хэлтсийн дарга)

А.Дашбат
(Иргэний төлөөлөл)

А.Гэрэлмаа
(Иргэний төлөөлөл)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын
2020 оны 100 дугаар тушаалын7 дугаар хавсралт

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**2024 он: Санхүүгийн хяналт, дотоод аудитын чанарын хяналтын үр нөлөөг сайжруулах**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /сая төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2023 он | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3.0 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **НЭГ. ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ** | | | | | | | |
| **Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааг төлөвлөгөөт цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэх стратеги зорилтын хүрээнд /Стратегийн зорилт 3.1.3-3.1.5/** | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 1.1:** Дотоод аудитын үйл ажиллагааг Олон улсын мэргэжлийн практикийн хүрээний стандарт, Улсын салбарын дотоод аудитын аргачлалд нийцүүлэн гүйцэтгэсэн байна. | | 215.9 | 1)Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1)ТЕЗ-ийн харьяаны эрсдэлд суурилсан төсөв захирагчдын үйл ажиллагаа, дотоод аудит хийсэн хяналт шалгалтын тоо<br>2)Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Улсын салбарын дотоод аудитын аргачлал<br>2.2)Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"<br>2.3) Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар батлагдсан "Дотоод аудитын чанарын үнэлгээний аргачлал",<br>2.4) Сангийн сайдын 2019 оны 29 дугаар тушаалаар батлагдсан "Дотоод аудитын хорооны дүрэм" | 1) Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) ТЕЗ-ийн харьяа 10 байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцад нэгдсэн санал дүгнэлт гаргасан.<br>2)Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Улсын салбарын дотоод аудитын аргачлалын дагуу дүгнэлт гаргаж холбогдох газарт хүргүүлсэн. | 1.)Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) ТЕЗ-ийн харьяа 31 обьектод дотоод аудитыг гүйцэтгэсэн байна.<br>2)Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Аудитыг чанартай гүйцэтгэж, удирдамжид заасан хугацаанд дүгнэлт, тайланг гаргаж Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн баталгаажуулан холбогдох байгууллагад хүргүүлэн хуулийн хугацаанд нийтэд ил тод болгосон байна. | 2024 онд хийж гүйцэтгэсэн хяналт шалгалтаар нийт 340 төрлийн 18,253.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 283.4 сая төгрөгийн 20 төлбөрийн акт тогтоон, цаашид зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 13,474.4 сая төгрөгийн 126 албан шаардлага, 4,499.0 сая төгрөгийн 163 зөвлөмж хүргүүлснээс төлбөрийн акт 53.7 хувьтай, албан шаардлага 77.5 хувьтай, зөвлөмжийн хэрэгжилт 80.5 хувьтай тайлагнагдсан байна. | **100.0%** |
| 1.1.1 | ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцад хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулан Дотоод аудитын хороогоор батлуулах, хэрэгжилтийг хангах тайлагнах | 192.8 | 1)Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) ТТЗ, ОНӨААТҮГ-ын санхүүгийн хяналт шалгалт хийх тоо<br>2)Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Улсын салбарын дотоод аудитын аргачлал<br>2.2)ДАОУИ-ээс батлсан ОУМПХ-ний стандартууд<br>2.3) Дотоод аудитын чанарын үнэлгээний аргачлал | 1)Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) ТЕЗ-ийн харьяа 10 байгууллагын үйл ажиллагааны дотоод аудитыг гүйцэтгэж дүгнэлтийг баталгаажуулсан<br>2)Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Улсын салбарын дотоод аудитын аргачлалын дагуу гүйцэтгэж тайлагнасан.<br>2.2) Сангийн яамнаас ТЕЗ-ийн 2021-2022 оны Дотоод аудитын үйл ажиллагаанд чанарын үнэлгээний хийсэн. | 1)Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) ТТЗ-ийн 9, ОНӨААТҮГ-ын 5, ХСС-ийн 17 обьектод дотоод аудит хийж баталгаажуулсан байна.<br>2)Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1)Санхүүгийн хяналт шалгалтын стандарт", аргачлалын дагуу гүйцэтгэж холбогдох газарт танилцуулан эцэслэсэн хяналт шалгалтын дүнг хуульд заасан хугацаанд олон нийтэд нээлттэй болгоно. | Дотоод аудитын хорооны үйл ажиллагааг Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу улирал тутамд хуралдуулж дараах асуудлуудыг шийдвэрлүүлэн, хэрэгжилтийн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Үүнд:<br>1.Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны үр дүн,<br>2.Байгууллагын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, хуваарь,<br>3.Дотоод аудитын хорооны Нарийн бичгийг томилуулах тухай.<br>4. Албаны бүтэц орон тоог шинэчлэн тогтоох тухай<br>5. Сангийн яамны нэгдсэн удирдамжаар хийгдсэн Гаалийн газрын 2022-2023 оны үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтын дүнгийн тухай<br>6. 17 сумын ХХС-ийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан<br>7. Шилэн дансны тухай хуулийн 2023 оны жилийн эцэс, 2024 оны 1 дүгээр улирлын хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын дүнгийн тухай, тус тус хэлэлцүүлж хорооны тогтоолоор дүнг баталгаажуулан цаашид авах арга хэмжээнүүдийг шалгагдагч байгууллагуудад мэдээллийг хүргүүлэн ажилласан тайлан мэдээг Сангийн яамны СХЭУГ-т хуульд заасан хугацаанд хүргүүлэхэд бэлэн болгосон. | 100.0% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.2 | Дотоод аудитын хорооны дүрэм"-ийн дагуу үйл ажиллагаа явуулж, хорооны хурлаар шийдвэрлэсэн асуудал, хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. | 19.6 | 1)Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэх дотоод аудитын хяналт шалгалтын тоо<br>2)Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Улсын салбарын дотоод аудитын аргачлал<br>2.2)Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"<br>2.3) Дотоод аудитын чанарын үнэлгээний аргачлал,<br>2.4) Сангийн сайдын 2019 оны 29 дугаар тушаалаар батлагдсан "Дотоод аудитын хорооны дүрэм" | 1)Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) ТЕЗ-ийн харьяа 10 байгууллагын үйл ажиллагааны дотоод аудитыг гүйцэтгэж дүгнэлтийг баталгаажуулсан<br>2)Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Улсын салбарын дотоод аудитын аргачлалын дагуу гүйцэтгэж тайлагнасан.<br>2.2) Сангийн яамнаас ТЕЗ-ийн 2021-2022 оны Дотоод аудитын үйл ажиллагаанд чанарын үнэлгээний хийсэн | 1)Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) ТШЗ, ТТЗ, ОНӨААТҮГ-ын нийт 15 байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудитын хяналт шалгалт хийсэн тоо<br>2)Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Аудитыг чанартай гүйцэтгэж, удирдамжид заасан хугацаанд дүгнэлт, тайланг гаргаж Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн баталгаажуулан холбогдох байгууллагад хүргүүлэн хуулийн хугацаанд нийтэд ил тод болгосон байна. | 2024 онд давхардсан тоогоор 260 байгууллагад эрсдэлийн үнэлгээнд суурилсан санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг гүйцэтгэхээр төлөвлөн 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөө хуваарийг Дотоод аудитын хороо"-оор батлуулан хэрэгжилтэд хяналт тавин хуваарийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу гүйцэтгэлээ.<br>Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны үр дүн,<br>Тус албанаас 2024 онд эрсдэлийн үнэлгээнд суурилан боловсруулсан санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын төлөвлөгөө, хуваарийг батлуулах тухай,<br>4. Дотоод аудитын хорооны Нарийн бичгийг томилуулах тухай.<br>5. Албаны бүтэц орон тоог шинэчлэн тогтоох тухай<br>Сангийн яамны нэгдсэн удирдамжаар хийгдсэн Гаалийн газрын 2022-2023 оны үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтын дүнгийн тухай<br>17 сумын ХХС-ийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлангийн үр дүнг баталгаажуулах тухай.<br>Шилэн дансны тухай хуулийн 2023 оны жилийн эцэс, 2024 оны 1-3 дугаар улирлын хэрэгжилт,<br>Хяналт шалгалтын төлөвлөгөөний сүүлийн хагас жилийн хэрэгжилт болон байгууллагын 2024 оны гүйцэтгэлийнхэрэгжилт, зорилтын хүрсэн түвшин болон хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хэрэгжилтийн биелэлтийг тус тус хэлэлцүүлж Дотоод аудитын хорооноос тайлант жилийн хугацаанд нийт хорооны 12 тогтоол гарсан байна. | 100.0% |
| 1.1.3 | Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2025 онд аудитад хамрагдах объектын эрсдэлийн үнэлгээг хийх, | 1.8 | 1 Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1 Төлөвлөсөн арга хэмжээний тоо 130<br>2. Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ 2120, Улсын салбарын дотоод аудитын аргачлал дагуу үнэлсэн эрсдэлийн үнэлгээ | 1 Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1)Тус газрын 2019-2023 онд гүйцэтгэсэн дотоод аудитыг 91 байгууллагад хийсэн.<br>2. Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1 Аудитын дүгнэлт, тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн | 1. Чанарын шалгуур үзүүлэлт<br>1.1)Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ 2120, Улсын салбарын дотоод аудитын аргачлал дагуу үнэлсэн байна. | Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас ТЕЗ-ийн эрхлэх хүрээний 130 байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалын дагуу гүйцэтгэж дотоод аудитад 15, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдах 20 байгууллагын эрсдэлийн үнэлгээнд суурилж 2024 онд хийгдэх хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулав. | 100.0% |
| 1.1.4 | ТАБ-аас ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байдалд бодит цагийн аудитыг гүйцэтгэх, тайлагнах | 3.5 | 1)Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) ТАБ-аас ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад өгсөн дүгнэлт, зөрчлийн тоо<br>2)Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Зөрчлийн хэрэгжилтийн хувь | 1)Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) 0<br>2)Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) 0 | 1)Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад хөндлөнгийн аудитын дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилтийн тоо<br>2)Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Аудитыг чанартай гүйцэтгэж, удирдамжид заасан хугацаанд дүгнэлт, тайланг гаргаж Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн баталгаажуулан холбогдох байгууллагад хүргүүлэн хуулийн хугацаанд нийтэд ил тод болгосон байна. | Тайлант жилийн хугацаанд ТТЗ-ийн 9, ТШЗ-ийн 18, ОНӨААТҮГ-ын 4 байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсан санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдалыг тогтоосон хугацаанд арилган цаашид дахин давтан гаргахгүй байхад авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 3 дугаар улирлын байдлаар газар дээр нь шалгахад аудитаар өгөгдсөн зөрчил дутагдалыг бүрэн арилгасан байна. | 100.0% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Гүйцэтгэлийн зорилт 1.2**: Санхүүгийн хяналт шалгалтыг стандарт, журам, заавар аргачлалд нийцүүлэн гүйцэтгэсэн байна. | | 175.8 | 1. Чанарын шалгуур үзүүлэлт<br>1.1. Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Санхүүгийн хяналт шалгалтын стандарт" | 1. Чанарын шалгуур үзүүлэлт<br>1.1. Санхүүгийн хяналт шалгалтын стандарт", аргачлалын дагуу төлөвлөгөөнд заасан хугацаанд гүйцэтгэж, тайлагнасан. | 2. Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1.СХШ-ыг чанартай гүйцэтгэж, удирдамжид заасан хугацаанд гүйцэтгэж дүгнэлт, тайланг аудитын хороогоор хэлэлцүүлэн баталгаажуулж холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар Сангийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр батлагдсан СХШХ/03 дугаартай Гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газар хороодын үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтын нэгдсэн удирдамжийн дагуу тус газрын 2022-2023 оны санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж 2024 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 44 дугаар албан бичгээр сангийн яамны санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт, 2024 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 43 дугаар албан бичгээр Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газарт санхүүгийн хяналт шалгалтын дүн хүргүүлэн ажилласан.<br>2024 08 дугаар сарын 08 дугаар сарын 27-ны өдрийн СХШХ/07 дугаартай Татварын ерөнхий газар болон түүний харьяа газар, хэлтсийн үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтын нэгдсэн удирдамжийн дагуу тус газрын 2022-2023 оны санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж 2024 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 44 дугаар албан бичгээр сангийн яамны санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт, 2024 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 43 дугаар албан бичгээр Сэлэнгэ аймгийн татварын хэлтэст санхүүгийн хяналт шалгалтын дүн хүргүүлэн ажилласан. | **100.0%** |
| 1.2.1 | Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж тайлагнах | 1.8 | 1. Тоон шалгуур үзүүлэлт<br>1.2) ТЕЗ-ийн харьяа байгууллагын тоо<br>2. Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1)Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилт хангагдсан байдал байршуулсан мэдээллийн хувь | 1. Тоон шалгуур үзүүлэлт<br>1.2) ТЕЗ-ийн харьяа байгууллагын тоо 285<br>2. Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилт хангагдсан байдал байршуулсан мэдээллийн 93 хувьтай тайлагнагдсан. | 1. Тоон шалгуур үзүүлэлт<br>1.2) ТЕЗ-ийн харьяа шилэн дансны мэдээлэл байршуулсан байгууллагын тоо 128<br>2. Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Шилэн дансны мэдээлэл байршуулсан байгууллагуудын биелэлтийн хувь 95 хувиас доошгүй байна. | 2024 оын жилийн эцсийн байдлаар ТЕЗ-н харьяа нийт 127 байгууллага нэгжид "Шилэн дансны тухай" хууль, ЗГ-н 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын хэрэгжилтэд улирал тутам хяналт тавин ажилласан.<br>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 81.3 хувь, 2 дугаар улиралд 83.8 хувь, 3 дугаар улиралд 90.5 хувьтай буюу 2024 оны 1 дүгээр улирлаас 9.2 хувиар төсөв, санхүүгийн мэдээллийн ил тод байдалд өссөн үзүүлэлтэй байгаа нь хяналтын шалгалтын үр илэрхийлж байна.<br>Шилэн дансны мэдээлэл байршуулалтын нийт хувь өссөн байгаа хэдий ч мэдээллийн чанар болоод мэдээлэл байршуултын хугацаа дээр Сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлтийг өгөн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | 100.0% |
| 1.2.2 | Төсөвт байгууллагуудын 2023-2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж стандартын дагуу гүйцэтгэж, хэрэгжилтийг тайлагнах | 170.4 | 1)Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) ТШЗ, ТТЗ, ОНӨААТҮГ-ын санхүүгийн хяналт шалгалт хийх тоо<br>2)Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Санхүүгийн хяналт шалгалтын стандарт" | 1)Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) 26 ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлтийг баталгаажуулсан<br>2)Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1)"Санхүүгийн хяналт шалгалтын стандарт", аргачлалын дагуу баталгаажуулж холбогдох газарт хүргүүлсэн | 1)Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) 20 Төсвийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг хийж баталгаажуулна.<br>2)Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1)Санхүүгийн хяналт шалгалтын стандарт", аргачлалын дагуу гүйцэтгэж холбогдох газарт танилцуулан эцэслэсэн хяналт шалгалтын дүнг хуульд заасан хугацаанд олон нийтэд нээлттэй болгоно. | Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас ТЕЗ-ийн эрхлэх хүрээний 130 байгууллагад эрсдэлийн үнэлгээг аргачлалын дагуу гүйцэтгэж санхүүгийн хяналт шалгалтад хамрагдах эрсдэл өндөр 20 байгууллагыг 2024 онд хийгдэх хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгасан батлуулан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаан ажиллаа. Санхүүгийн хяналт шалгалтаар нийт 1,782.5 сая төгрөгийн 143 зөрчил илрүүлснээс 9.9 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт, 1,472.0 сая төгрөгийн зөрчилд 55 албан шаардлага, 300.9 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 43 зөвлөмж хүргүүлэн хэрэгилтэд хяналт тавиин ажилласан. | 100.0% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.3 | Дотоод Аудит-хяналт шалгалтын удирдлагын мэдээллийн нэгдсэн системийг ТЕЗ-ийн түвшинд шинээр нэвтрүүлэх | 1.8 | 1 Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1 Аудитын нэгдсэн системд оруулах байгууллагын тоо<br>2. Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Сангийн сайдын 2023 оны 35 дугаар тушаал, Улсын салбарын дотоод аудитын аргачлал | 1 Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) 0<br>2. Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1 0 | 1 Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1 Аудитын нэгдсэн системд оруулсан байгууллагын тоо<br>2. Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Сангийн сайдын 2023 оны 35 дугаар тушаал, Улсын салбарын дотоод аудитын аргачлал дагуу гүйцэтгэсэн мэдээллийн нэгдсэн дата бааз үүссэн байна. | Дотоод Аудит-хяналт шалгалтын удирдлагын мэдээллийн нэгдсэн системийг ТЕЗ-ийн түвшинд шинээр нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар гүйцэтгэж системийн хэрэглэгчийн хандах эрхийг тохируулан 127 харилцагч байгууллагын мэдээллийг системд бүртгэсэн ба албан хаагчдыг Сангийн яамнаас 2024 оны 05 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулсан төсвийн бусийн төрийн байгууллагын дотоод аудиторууд, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчдыг чадавхжуулах сургалтад хамруулан систем дээр ажиллах ур чадварыг эзэмшүүлсэн.<br>Цаашид тус системд гүйцэтгэсэн хяналт шалгалт, дотоод аудитын үе шатны ажлуудыг горим, стандартын дагуу мэдээллийг оруулж дата бааз үүсгэх ажлыг гүйцэтгэж ажилласан. | 100.0% |
| 1.2.4 | Санхүүгийн хяналт шалгалтад 2025 онд хамрагдах объектын эрсдэлийн үнэлгээг хийх | 1.8 | 1 Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1 Төлөвлөсөн арга хэмжээний тоо<br>2. Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Сангийн сайдын 2019 оны 291 дүгээр тушаалаар батлагдсан "Сангийн яамны эрсдэлийн удирдлагын бодлого, дүрэм, журам" | 1 Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1)Тус газрын 2019-2023 онд гүйцэтгэсэн дотоод аудитын нэгдсэн дүгнэлтийг 91 байгууллагад дотоод аудит хийгдсэн.<br>2. Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1 | 1 Чанарын шалгуур үзүүлэлт<br>1.1)Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ 2120, Улсын салбарын дотоод аудитын аргачлал дагуу үнэлсэн байна. | Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас ТЕЗ-ийн эрхлэх хүрээний 130 байгууллагад эрсдэлийн үнэлгээг аргачлалын дагуу гүйцэтгэж санхүүгийн хяналт шалгалтад хамрагдах эрсдэл өндөр 20 байгууллагыг 2024 онд хийгдэх хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгасан. | 100.0% |
| **Гүйцэтгэлийн зорилт 1.3:** Санхүүгийн хяналт, дотоод аудитын үйл ажиллагаагаар нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангаж үр дүн, хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах | | 9.0 | 1. Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1.Санхүүгийн хяналт, дотоод аудитын үйл ажиллагааны үр дүнг нэгтгэсэн хэрэгжилтийн тайлангийн тоо<br>2. Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын гүйцэтгэл. хугацаа. аудитын арга зүй, санхүүгийн хяналт шалгалтын стандарт мөрдөлтийн хувь 100 | 1. Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1.Санхүүгийн хяналт, дотоод аудитын үйл ажиллагааны үр дүнг нэгтгэсэн хэрэгжилтийн тайлан<br>2 Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1.Дотоод аудитын гүйцэтгэл. хугацаа, аудитын арга зүй, Санхүүгийн хяналт шалгалтын стандарт мөрдөлтөд нэгдсэн удирдлага, зохицуулалт хийж ажилладаг. | 1. Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1.Санхүүгийн хяналт, дотоод аудитын үйл ажиллагааны үр дүнг нэгтгэсэн хэрэгжилтийн тайлан<br>2. Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1.Дотоод аудитын гүйцэтгэл, хугацаа. аудитын арга зүй, санхүүгийн хяналт шалгалтын стандарт мөрдөлтөд нэгдсэн удирдлага, зохицуулалт хийж ажиллана. 100% | 2024 оны жилийн эцсийн байдлаар мэргэжил арга зүйгээр ханган гүйцэтгэсэн хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлт, хэрэгжилтэд хяналт тавин удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласны үр дүнд ТЕЗ-ийн эрхлэх хүрээний харьяа байгууллагуудын 18,253.7 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан. | **96.3%** |
| 1.3.1 | Улсын салбарын дотоод аудитын тогтолцоог бэхжүүлэх чанарын үнэлгээний аргачлалын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, үр дүнг нэгтгэн тайлагнах | 1.8 | 1. Чанарын шалгуур үзүүлэлт<br>1.1 ДАОУИ-ын ОУМПХ-ний 1000-2600 стандартууд | 1 Чанарын шалгуур үзүүлэлт<br>1 1.Нийцээгүй | 1 Чанарын шалгуур үзүүлэлт<br>1.1 Улсын салбарын чанарын үнэлгээний аргачлалыг нэвтрүүлэн хэсэгчлэн нийцсэн үнэлгээнд хүргэсэн байна. | Сангийн сайдын 2019 оны 274 дүгээр тушаалаар баталсан "Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх журам"-ын хэрэгжилтийг хангаж Улсын салбарын дотоод аудитын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр стандартын хэрэглээг албаны үйл ажиллагаанд хэвшүүлэх чиглэлээр чанарын үнэлгээний аргуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Үүнд:<br>Байнгын хяналтын үнэлгээг аудитын үе шат бүр дээр хэрэгжүүлж хэвшсэн ба цаашлаад тогтмол хугацаанд хийх өөрийн үнэлгээг хийхээр төлөвлөн ажилласан. | 100.0% |
| 1.3.2 | Хяналт шалгалтын танилцуулга хуудас бэлтгэн эцэслэн гаргасан дүнг олон нийтэд нээлттэй болгох | 1.8 | 1 Тоон шалгуур үзүүлэлт<br>1 1 Хураангуй болон инфо тайлангийн тоо<br>2 Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1 Биелэлтийн хувь | 1 Тоон шалгуур үзүүлэлт<br>1 1 Хяналт шалгалтын танилцуулгын тоо<br>2 Чанарын шалгуур үзүүлэлт<br>2 1 80.0 хувь | 1 Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1 Олон нийтэд хүргэсэн хураангуй болон инфо тайлангийн тоо<br>2.Чанарын шалгуур үзүүлэлт<br>2 1 .Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан дагуу нийтэд ил тод нээлттэй болгосон байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар хийж гүйцэтгэсэн ХХС-ийн үйл ажиллагааны үр дүн, Гаалийн газрын 2022-2023 оны үйл ажиллагааны үр дүн, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын дүн, Иргэдээс төрийн байгууллага, эрх бүхий албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдолд хийсэн хяналт шалгалтын танилцуулгын холбогдох албан тушаалтан, иргэнд хүргүүлж олон нийтэд хяналт шалгалтын үр дүнг нийтэд мэдээлсэн. | 100.0% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.3.3 | Санхүүгийн хяналт, дотоод аудитын дүн, дүгнэлт, өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хэрэгжилтийг тайлагнах үр дүнг тооцох | 1.8 | 1 Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1 Санхүүгийн хяналт шалгалтаар өгсөн акт, албан шаардлага, дотоод аудитаар өсгөн зөвлөмж<br>2.Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1 Биелэлтийн хувь | 1 Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1.2023 онд Санхүүгийн хяналт шалгалтаар 5.4 сая төгрөгийн албан шаардлага, 62 зөвлөмж хүргүүлсэн<br>2 Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) 100 хувь | 1 .Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1 .Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаар өгсөн акт, албан шаардлага. зөвлөмжийн тоог статистик мэдээнд баталгаажуулсан байна.<br>2 Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1.Биелэлт 85.0 хувиас багагүй байна. | 2024 онд хийж гүйцэтгэсэн хяналт шалгалтаар нийт 340 төрлийн 18,253.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 283.4 сая төгрөгийн 20 төлбөрийн акт тогтоон, цаашид зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 13,474.4 сая төгрөгийн 126 албан шаардлага, 4,499.0 сая төгрөгийн 163 зөвлөмж хүргүүлснээс төлбөрийн акт 53.7 хувьтай, албан шаардлага 77.5 хувьтай, зөвлөмжийн хэрэгжилт 80.5 хувьтай тайлагнагдсан байна. | 77.7% |
| 1.3.4 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хянах тавих төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнах | 1.8 | 1 Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1 Төлөвлөсөн арга хэмжээний тоо<br>2. Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1 Төлөвлөгөөний биелэлтийн хувь | 1 Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хянах тавих<br>2. Чанарын шалгуур үзүүлэгд<br>2.1.0.0 | 1 Тоон шалгуур үзүүлэлт<br>1,1.16 арга хэмжээ<br>2. Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1 Төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тайлагнасан, биелэлт 80.0 хувиас багагүй байна | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус албаны 2024 оны үйл ажиллагаанд 456.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 394.2 сая төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 86.3 хувьтай буюу 62. сая төгрөг буюу 13.7 хувиар хэмнэж ажиллаа . Үүнд цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 27.5 сая төгрөгөөр, Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 4.4 сая төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардлыг 7.1 сая төгрөгөөр, Эд хогшил, урсгал засварын зардлыг 1.8 сая төгрөгөөр, томилолтын зардлыг 5.3 сая төгрөгөөр , бусад зардлыг 16.2 сая төгрөгөөр тус тус хэмнэж төсвийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэн ажилласан. | 100.0% |
| 1.3.5 | Улсын салбарын дотоод аудит үүсэж хөгжсөний 10 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, тайлагнах | 1.8 | 1 Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1 Төлөвлөсөн арга хэмжээний тоо<br>2. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт<br>2.1) Биелэлтийн хувь | 1 Тоон шалгуур үзүүлэлт:<br>1.1 0<br>2. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт<br>2.1) 0 | 1 Тоон шалгуур үзүүлэлт:<br>1.1 Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн тоо<br>2. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт<br>2.1) Улсын салбарын дотоод аудитын тогтолцоог бэхжүүлэх, сурталчлах, дотоод аудитын чанарын үр нөлөөг сайжруулсан байна. | Орон нутагт Улсын салбарын дотоод аудит үүсэж хөгжсөний 10 жилийн ойг угтан ТЕЗ-ийн эрхлэх хүрээн төсвийн байгууллага, ОНӨААТҮГ-ын төсвийн захирагч, санхүүгийн ажилтнуудыг чадавхжуулах нэгдсэн сургалтыг салбарын төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулж тус сургалтад нийт 140 албан хаагчийг чадавхжуулах сургалтад хамруулсан.<br>Мөн байгууллагын 10 жилийн түүхэн замналыг агуулсан номыг бүтээж Улсын салбарын дотоод аудитыг олон нийтэд сурталчилан таниулах арга хэмжээг зохион байгуулж ажилласан. | 100% |
| 1.3.6 | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчлэн боловсруулж төслийг бие бүрэлдэхүүнээр хэлэлцүүлэн баталгаажуулах | 1.8 | 1 .Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1)Батлагдсан журмын тоо<br>2.Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Хөдөлмөрийн тухай хуулийн 112 дугаар зүйл. Хөдөлмөрийн дотоод журам | 2 .Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1)Батлагдсан журмын тоо 1<br>2.Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Байгууллагын даргын 2022 оны А/22 дугаар тушаалаар баталсан байна. | 3 .Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1)Батлагдсан журмын тоо 1<br>2.Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Ажил олгогч ажилтны саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ. | Албаны даргын 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн А/01 дугаар тушаалаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлаж энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн А/02 дугаар тушаалын хүчингүй болгосон. Тайлант жилийн хугацаанд байгууллагын дотоод үйл ажиллагааг тус журмын дагуу зохион байгуулж ажилласан. | 100% |
| **ХОЁР.НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ** | | | | | | |
| **Нийгмийн бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээний асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх мэдлэг чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх стратегийн зорилтын хүрээнд** | | | | | | |
| | **Гүйцэтгэлийн зорилт 2.1**: Санхүүгийн хяналт, дотоод аудитын байгууллагын хүний нөөцийг бүрдүүлж чадамжийг сайжруулах | 32.1 | 1. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт<br>1.1 Хамт олны сэтгэл ханамжийн үнэлгээний ахиц<br>1.2. Тайлант хугацаанд дэмжих үйлчилгээтэй холбоотой гарсан гомдол саналын хүсэлтийн тоо | 1) Үр дүнгийн шалгуур үзүүлэлт<br>1.1) (өмнөх жилүүдэд ийм судалгаа хийгдээгүй)<br>1.2) 0 | 1. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт<br>1.1 50 хувь<br>1.2.0 | Тус алба нь аймгийн Засаг даргын 2022 оны А/75 дугаар захирамжаар баталсан бүтэц орон тоог 8 байхаар баталсан ба эхний хагас жилийн байдлаар дутуу байсан 3 орон тоог хууль тогтоомжид нийцүүлэн сонгон шалгаруулж орон тооны хангалтыг 100 хувьд хүргэн ажиллаа.<br>Мөн аймгийн Засаг даргын 2024 оны А/279 дүгээр захирамжаар бүтэц орон тоог шинэчлэн тогтоолгож 12 болгох ажлыг зохион байгуулж албажуулснаар тус албаны үйл ажиллагааны үр дүнг дээшилсэн байна. | **100.0%** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.1 | Хүний нөөцийн бодлого үйл ажиллагаар төлөвлөх Төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран сул орон тоог нөхөх арга хэмжээг ил тод нээлттэй хэрэгжүүлэх, тайлагнах | 21.1 | 1 .Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1)Нэгдсэн сургалтад хамруулсан албан хаагчдын тоо<br>1.2 Зэрэг дэв болон бусад нэмэгдлийг шинээр болон ахиулан олгосон албан хаагчдын тоо<br>2.Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1)Батлагдсан орон тооны дагуу ажилласан байдал<br>2.2) Хүний нөөцийн чиглэлээр ТАЗ-өөс өгсөн чиглэлийн хэрэгжилтийн хувь | 1 .Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1)Хэрэгжилтийг нэгтгэн тайлагнасан тоо 6<br>2.Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1)Төлөвлөгөөний дагуу 5 албан хаагч сургалтад бүрэн хамрагдсан | 1 .Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) Төлөвлөгөөнд тусгагдсан сургалтын тоогоор<br>2.Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1)Сургалтын төлөвлөгөөний дагуу тогтоосон хугацаанд бүрэн хамрагдсан байна | Тус албаны сул орон тоог нөхөх хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж Төрийн албаны салбар зөвлөлд сул орон тооны мэдээллийг эхний хагас жилийн байдлаар албан бичгээр 4 удаа хүргүүлж албаны цахим хуудсаар олон нийтэд мэдээлж ажилласны үр дүнд дутуу байсан 3 орон тоог сонгон шалгаруулалтын журмын дагуу бүрдүүлж чадсан.Үүний үр дүнд албаны үйл ажиллагааг хэвийн явуулах, ажиллаж байгаа албан хаагчдад ирэх ачааллыг 50 хувиар бууруулж хүний нөөцийн ил тод байдлыг ханган ажилласан. | 100.0% |
| 2.1.2 | Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны бүтэц орон тооны өөрчлөлт оруулах судалгааны үр дүнд үндэслэсэн саналын хувилбарыг боловсруулан Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх | 1.8 | 1 .Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) Батлагдсан орон тооны өөрчлөлтийн тоо<br>2. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт<br>2.1) Сангийн сайдын 2023 оны 35 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Улсын салбарын дотоод аудитыг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөрийн 1.3.1 заасан арга хэмжээ | 1 .Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) Батлагдсан орон т тоо 8<br>2. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт<br>2.1) Дотоод аудитын үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалт шинэ шатанд гарсан байна.Биелэлтийн хувь | 1 .Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) Батлагдсан орон тоо<br>2. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт<br>2.1) Дотоод аудитын хараат бус байдлаар хангагдах тогтолцоо үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалт шинэ шатанд гарсан байна. | Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны бүтэц орон тооны өөрчлөлт оруулах судалгааг 10 аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас авч үр дүнд үндэслэсэн саналын хувилбарыг боловсруулан Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн 2 удаа хэлэлцүүлсний үр дүнд бүтэц орон тоог шинэчлэн тогтоохыг дэмжсэн тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2024 оны А/279 дүгээр захирамжаар 4 орон тоог шинээр нэмэгдүүлэн дүрмийг шинэчлэн батлуулсан. | 100.0% |
| 2.1.3 | Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны бүтэц орон тооны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн шийдвэрлүүлэх | 1.8 | 2 .Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) Батлагдсан орон тооны өөрчлөлтийн тоо<br>2. Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1) Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам" | 1 .Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) Батлагдсан орон т тоо 8<br>2. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт<br>2.1) Төрийн албаны зөвлөлөөр зөвшөөрсөн албан тушаалын тодорхойлолт 3 байгаа нь Засаг даргын 2022 оны А/75 дугаар захирамжаар баталсан бүтэц орон тоотой уялдаагүй байна. | 2 .Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) Батлагдсан орон т тоо 10<br>2. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт<br>2.1) Төрийн албаны зөвлөлөөр бүтэц орон тооны өөрчлөлтэй уялдуулан байгууллагын хэвийг үйл ажиллагааг хангах, дотоод аудитын оновчтой ажил, чиг үүргийн уялдааг хангах | 1.1 Улсын хэмжээнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга, санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, дотоод /ахлах/ аудиторын албан тушаалын тодорхойлолтыг нэг жишиг болон шинэчлэн боловсруулж нэгдсэн журмаар Төрийн албаны зөвлөлөөр батлуулах саналыг Дархан, Төв аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албатай хамтран Сангийн сайдад хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.<br>1.2 Аймгийн Засаг даргын 2024 оны А/279 дугаар захирамжаар байгууллагын бүтэц орон тоог шинэчлэн 12 орон тоотой болгон өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг шинээр боловсруулах ажлын хэсгийг байгууллагын даргын 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/12 дугаар тушаалаар байгуулж албан тушаалын тодорхойлолтыг төслийг боловсруулан ТАЗ-д хүргүүлсэн. | 100.0% |
| 2.1.4 | Байгууллагын 2024 оны дотоод сургалтын нэгдсэн төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх, тайлагнах | 5.6 | 1 .Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1)Дотоод сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан сургалтын тоо<br>2.Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1)Төлөвлөгөөний дагуу сурталтанд бүрэн хамрагдсан байдал | 1 .Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1)Хэрэгжилтийг нэгтгэн тайлагнасан тоо 6<br>2.Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1)Төлөвлөгөөний дагуу 5 албан хаагч сургалтад бүрэн хамрагдсан | 1 .Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1) Төлөвлөгөөнд тусгагдсан сургалтын тоогоор<br>2.Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1)Сургалтын төлөвлөгөөний дагуу тогтоосон хугацаанд бүрэн хамрагдсан байна | Байгууллагын 2024 оны дотоод сургалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан тайлант жилийн хугацаанд Төрийн албаны зөвлөлөөс цахимаар зохион байгуулсан 19 сургалт, байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу 10 сургалт, бусад байгууллагаас 6 сургалт тус тус зохион байгуулагдаж, давхардсан тоогоор нийт 350 албан хаагчдыг хамруулж, мэдлэг чадварыг дээшлүүлэн ажилласан. | 100.0% |
| **Монгол улсын урт хугацааны хөгжлийн баримт бичгийг хэрэгжүүлэхэд Санхүүгийн хяналт, дотоод аудитын байгууллагын оролцоог нэмэгдүүлэх** | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 2.2:** Тогтвортой хөгжлийн засаглалын бодлогыг хэрэгжүүлж, бодлогын баримт бичиг, үүрэг даалгаврын хэрэгжилтийн эрчимжүүлэх замаар гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх; | | 12.6 | 1) Үр дүнгийн шалгуур үзүүлэлт<br>1.1) Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн дундаж хувь | 1) Үр дүнгийн шалгуур үзүүлэлт<br>1.1) 87.0 хувь | 1) Үр дүнгийн шалгуур үзүүлэлт<br>1.1) 90.0 хувь | Улсын салбарын дотоод аудитын үйл ажиллагааг орон нутагт чанарын нэгдсэн түвшинд хүргэх, Дотоод аудитын чадавхыг бэхжүүлэхэд байгууллагын бүтэц орон тоог нэмэгдүүлж, албан хаагчдын тасралтгүй хөгжлийн сургалтыг явуулан мэдлэг ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. | **100.0%** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.1 | Хууль тогтоомж, тогтоолын шийдвэрийн хэрэгжилтийг хангах | 1.8 | 1) Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1.Батлагдсан төлөвлөгөөний тоо<br>1.2.Хугацаанд нь тайлагнасан тайлангийн тоо<br>2) Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1.Хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийн хувь | 1. Тоон шалгуур үзүүлэлт<br>1 1 Улирал, Хагас, бүтэн жилийн хэрэгжилтийн тайлан гардаг<br>2.Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1.Хэрэгжилтийн хувь | 1 Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1. Бодлогын баримт бичиг хөтөлбөр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн тоогоор<br>2.Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1Хэрэгжүүлэх арга хэмжээг тогтоосон хугацаанд бүрэн тайлагнасан байна | 2024 онд нийт 183 обьект үүнээс 17 сан, 166 байгууллагын үйл ажиллагаанд аудит болон санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэснээс шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар 128 байгууллагыг улирал тутам хяналт тавин ажиллаж, 25 Төсвийн шууд захирагчид санхүүгийн хяналт шалгалт, 9 Төсвийн төвлөрүүлэн захирагч, 4 ОНӨААТҮГ-т дотоод аудит 17 сумын Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитыг тус тус хийж хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулсан ажилласан. | 100.0% |
| 2.2.2 | Улсын салбарын дотоод аудитыг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | 1.8 | 1) Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1.Батлагдсан төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний тоо<br>1.2.Хугацаанд нь тайлагнасан арга хэмжээний тоо<br>2) Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1.Хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийн хувь | 1. Тоон шалгуур үзүүлэлт<br>1 1. 0<br>2.Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1.Хэрэгжилтийн хувь 0 | 1) Тоон шалгуур үзүүлэлт<br>1.1.Батлагдсан төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн тоогоор<br>1.2.Хугацаанд нь тайлагнасан арга хэмжээний тоогоор<br>2) Чанарын шалгуур үзүүлэлт<br>2.1.Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний биелэлтийг тайлагнасан байна | Улсын салбарын дотоод аудитын үйл ажиллагааг орон нутагт чанарын нэгдсэн түвшинд хүргэх, Дотоод аудитын чадавхыг бэхжүүлэх, Дотоод аудитын бие даасан хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, төрийн үйлчилгээ, үйл ажиллагааны засаглалыг бэхжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор батлагдсан 2023-2025 онд хэрэгжүүлэх "Улсын салбарын дотоод аудитыг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө"-ний хэрэгжилт хангах чиглэлээр Сангийн яамны СХЭУГ болон Сангийн сайдад авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан хүргүүлсэн.<br>1.2 Мөн бүтэц зохион байгуулалтыг шинээр хийж хүний нөөцийн бодлого төлөвлөлтийг сайжруулах, орон тоог нэмэгдүүлэх, чиглэлээр аймгийн Засаг даргын А/279 дугаар захирамжаар тус албаны бүтэц орон тоог шинэчлэн батлуулсан.<br>1.3 Монголын мэргэшсэн дотоод аудиторуудын институттэй хамран 5 албан хаагчийг мэргэшсэн дотоод аудитор бэлтгэх мэргэшүүлэх сургалтад хамруулсан. | 100.0% |
| Нийт дүн | | **1,782.5** | **1,782.5** | **1,569.8** | **212.7** | **88.1%** |

Санхүүгийн хяналт шалгалтаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.




# ГУРАВ. ДОТООД АУДИТ

Дотоод аудитаар нийт 101 төрлийн 8,162.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 26.4 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоон, цаашид зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 7,605.7 сая төгрөгийн 46 албан шаардлага, 530.5 сая төгрөгийн 48 зөвлөмж хүргүүлсэн болно.

**Хүснэгт 3. Дотоод аудитаар илрүүлсэн зөрчил 2024 он**

/сая.төг/

| Төсвийн захирагч | Хамрагдсан байгууллага | Илрүүлсэн алдаа, зөрчил | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн |
| ТЕЗ | - | - | - | - | - | - | - | - | - |
| ТТЗ | 9 | 58 | 4,293.5 | 1 | 18.0 | 33 | 4,128.0 | 24 | 147.5 |
| ОНӨААТҮГ | 4 | 43 | 3,869.1 | 3 | 8.4 | 16 | 3,477.7 | 24 | 383.0 |
| **Нийт** | 13 | **101** | **8,162.5** | **4** | **26.4** | **46** | **7,605.7** | **48** | **530.5** |

**Хүснэгт 4. Тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, 2024 он** /сая.төг/

| Шийдвэр | Илрүүлэлт | | Хэрэгжсэн | | Дараа онд шилжих үлдэгдэл | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | Эхний үлдэгдэл | Тайлант хугацаанд | Нийт | Биелсэн | | |
| Акт | | 26.4 | 26.4 | 24.5 | 1.9- | 92.9% |
| Албан шаардлага | | 7,605.7 | 7,605.7 | 5,274.3 | 2,331.4 | 69.3% |
| Зөвлөмж /тоо/ | | 530,5 | 530,5 | 434.9 | 95.6 | 82.0% |
| Нийт дүн | | **8,162.5** | **8,162.5** | **5,733.7** | **2,428.9** | **70.2%** |

Дотоод аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараахь байдалтай байна.




# ДӨРӨВ. НИЙЦЛИЙН АУДИТ

2024 оны жилийн эцсийн байдлаар ТЕЗ-ийн харьяа нийт 128 байгууллага нэгжид "Шилэн дансны тухай" хууль, ЗГ-н 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын хэрэгжилтэд ТЕЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 02 дугаар удирдамжийн хүрээнд улирал тутам хяналт тавин ажиллаа

**Хүснэгт 5. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 1-3 дугаар улирлын байдлаар, 2024 он**

| № | Байгууллагын нэрс | Байгууллагын тоо | хэрэгжилтийн хувь | | | Дүгнэлтийн төрөл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | /1-р улирал/ | /2-р улирал/ | /3-р улирал/ | |
| 1 | Баруунбүрэн сум | 5 | 58.1 | 61.5 | 60.1 | Хангалтгүй |
| 2 | Түшиг сум | 5 | 59 | 57 | 71.4 | Хангалтгүй |
| 3 | Орхонтуул сум | 6 | 91 | 73.7 | 79.5 | Хангалтгүй |
| 4 | Шаамар сум | 6 | 61.4 | 64.3 | 79.8 | Хангалтгүй |
| 5 | Мандал сум | 7 | 72.4 | 72.7 | 82.8 | Сайжруулах шаардлагатай |
| 6 | Төсвийн ерөнхийлөн захирагч | 8 | 80.1 | 82.4 | 84.3 | Сайжруулах шаардлагатай |
| 7 | ОНӨААТҮГ | 23 | 93 | 86.7 | 93.5 | Хангалттай |
| 8 | Орхон сум | 5 | 95 | 74.2 | 93.6 | Хангалттай |
| 9 | Сайхан сум | 7 | 71.8 | 93.7 | 95.5 | Хангалттай |
| 10 | Сант сум | 5 | 75.7 | 66.9 | 95.6 | Хангалттай |
| 11 | Баянгол сум | 5 | 72.5 | 93.8 | 96.1 | Хангалттай |
| 12 | Ерөө сум | 6 | 94.8 | 97.6 | 96.4 | Хангалттай |
| 13 | Зүүнбүрэн сум | 5 | 95.9 | 95.5 | 96.8 | Хангалттай |
| 14 | Хушаат сум | 5 | 85.6 | 96.6 | 96.9 | Хангалттай |
| 15 | Хүдэр сум | 5 | 58.1 | 85.7 | 97.4 | Хангалттай |
| 16 | Алтанбулаг сум | 5 | 80.2 | 97.7 | 98 | Хангалттай |
| 17 | Ойн анги | 5 | 94.2 | 97.7 | 98.2 | Хангалттай |
| 18 | Сүхбаатар сум | 5 | 61.7 | 78.4 | 98.5 | Хангалттай |
| 19 | Цагааннуур сум | 5 | 97.7 | 100 | 99.5 | Хангалттай |
| 20 | Жавхлан сум | 5 | 100 | 100 | 99.7 | Хангалттай |
| Нийт дүн | | 128 | 81.7 | 83.8 | 90.5 | |

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар81.3 хувь, 2 дугаар улиралд 83.8 хувь, 3 дугаар улиралд 90.5 хувьтай буюу 2024 оны 1 дүгээр улирлаас 9.2 хувиар өсөв, санхүүгийн мэдээллийн ил тод байдалд өссөн үзүүлэлтэй байгаа нь хяналтын шалгалтын үр дүнг илэрхийлж байна.

Шилэн дансны мэдээлэл байршуулалтын нийт хувь өссөн байгаа хэдий ч мэдээллийн чанар болоод мэдээлэл байршуулалтын хугацаа дээр Сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлтийг өгөн хэрэгжилтийг хангуулах зөвлөмжийг ТЕЗ-аас харьяа байгууллагуудад албан бичгээр 2 удаа хүргүүлэн ажилласан.

Тайлант жилийн хугацаанд тус албанаас ТЕЗ-ийн эрхлэх хүрээний төсвийн болон ОНӨААТҮГ-ын санхүүгийн ил тод байдлыг сайжруулах "Удирдлагын манлайл-Ил тод байдал" арга хэмжээний үр дүн зорилтод түвшинг бүрэн хангуулж төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэн ажиллаа.

2024 оны жилийн эцсийн мэдээлэл байршуулалтын ил тод байдлыг шалгах хуулийн хугацаа болоогүй байгаа болно.

# ТАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ТЕЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 тоот удирдамжийн хүрээнд 17 сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2021-2023 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгэн 17 сумын ТТЗ-д аудитын дүгнэлт, тайланг хүргүүллээ.

**Хүснэгт 6. Гүйцэтгэлийн аудитаар илэрүүлсэн зөрчил, 2024 он**

/сая.төг/

| Төсвийн захирагч | Хамрагдсан байгууллага | Нийт | | Илрүүлсэн алдаа зөрчил | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн/сая төгрөг/ | Тоо | Дүн /сая төгрөг/ | Тоо | Дүн /сая төгрөг/ | Тоо | Дүн/сая төгрөг/ |
| ТТЗ | Алтанбулаг сумын Хоршоог хөгжүүлэх сан | 8 | 318.2 | 1 | 2.7 | 2 | 154.8 | 5 | 160.6 |
| ТТЗ | Баруунбүрэн сумын Хоршоог хөгжүүлэх сан | 8 | 240.4 | | | 4 | 181.8 | 4 | 58.5 |
| ТТЗ | Баянгол сумын Хоршоог хөгжүүлэх сан | 3 | 39.9 | | | | | 3 | 39.9 |
| ТТЗ | Ерөө сумын Хоршоог хөгжүүлэх сан | 6 | 712.9 | 1 | 17.5 | 1 | 391.0 | 4 | 304.4 |
| ТТЗ | Жавхлант сумын Хоршоог хөгжүүлэх сан | 5 | 102.9 | | | | | 5 | 102.9 |
| ТТЗ | Зүүнбүрэн сумын Хоршоог хөгжүүлэх сан | 3 | 25.1 | | | | | 3 | 25.1 |
| ТТЗ | Мандал сумын Хоршоог хөгжүүлэх сан | 7 | 1,578.6 | 1 | 6.2 | 2 | 940.9 | 4 | 631.4 |
| ТТЗ | Орхон сумын Хоршоог хөгжүүлэх сан | 2 | 25.0 | | | | | 2 | 25.0 |
| ТТЗ | Орхонтуул сумын Хоршоог хөгжүүлэх сан | 6 | 429.5 | | | 1 | 200.2 | 5 | 229.3 |
| ТТЗ | Сайхан сумын Хоршоог хөгжүүлэх сан | 9 | 693.9 | 1 | 8.2 | 2 | 469.9 | 6 | 215.8 |
| ТТЗ | Сант сумын Хоршоог хөгжүүлэх сан | 3 | 42.8 | | | | | 3 | 42.8 |
| ТТЗ | Сүхбаатар сумын Хоршоог хөгжүүлэх сан | 11 | 2,292.2 | 1 | 179.0 | 2 | 1,067.3 | 8 | 1,045.9 |
| ТТЗ | Түшиг сумын Хоршоог хөгжүүлэх сан | 6 | 259.2 | 1 | 1.8 | 1 | 155.4 | 4 | 102.0 |
| ТТЗ | Хушаат сумын Хоршоог хөгжүүлэх сан | 7 | 340.2 | | | 4 | 204.6 | 3 | 135.7 |
| ТТЗ | Хүдэр сумын Хоршоог хөгжүүлэх сан | 7 | 258.4 | | | 2 | 204.2 | 5 | 54.2 |
| ТТЗ | Цагааннуур сумын Хоршоог хөгжүүлэх сан | 6 | 284.5 | 1 | 2.2 | 1 | 175.8 | 4 | 106.6 |
| ТТЗ | Шаамар сумын Хоршоог хөгжүүлэх сан | 8 | 664.8 | 1 | 29.7 | 3 | 247.8 | 4 | 387.3 |
| **Нийт дүн** | | **105** | **8,308.6** | **8** | **247.4** | **25** | **4,393.7** | **72** | **3,667.6** |

Гүйцэтгэлийн аудитаар нийт 105 төрлийн 8,308.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 247.7 сая төгрөгийн 8 төлбөрийн акт тогтоон, цаашид зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 4,393.7 сая төгрөгийн 25 албан шаардлага, 3,667.6 сая төгрөгийн 72 зөвлөмж хүргүүлсэн болно.

**Хүснэгт 7. Тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, 2024 он** /сая.төг/

| Шийдвэр | Илрүүлэлт | | | Хэрэгжсэн | Дараа онд шилжих үлдэгдэл | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | Эхний үлдэгдэл | Тайлант хугацаанд | Нийт | Биелсэн | | |
| Акт | | 247.4 | 247.4 | 118.2 | 129.0 | 47.8% |
| Албан шаардлага | | 4,393.7 | 4,393.7 | 3,821.0 | 572.6 | 87.0% |
| Зөвлөмж /тоо/ | | 3,667.6 | 3,667.6 | 2,946.5 | 721.1 | 80.3% |
| Нийт дүн | | **8,308.6** | **8,308.6** | **6,885.8** | **1,422.9** | **82.9%** |

Гүйцэтгэлийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.




Тайлант оны хяналт шалгалтаар нийт 340 төрлийн 18,253.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 283.4 сая төгрөгийн 20 төлбөрийн акт тогтоон, цаашид зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 13,474.4 сая төгрөгийн 126 албан шаардлага, 4,499.0 сая төгрөгийн 163 зөвлөмж хүргүүлсэн болно.

**Хүснэгт 8. 2024 оны хяналт шалгалтаар тогтоосон нийт төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, 2024 он** /сая.төг/

| Шийдвэр | Илрүүлэлт | | | Хэрэгжсэн | Дараа онд шилжих үлдэгдэл | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | Эхний үлдэгдэл | Тайлант хугацаанд | Нийт | Биелсэн | | |
| Акт | | 283.4 | 283.4 | 152.3 | 131.1 | 53.7% |
| Албан шаардлага | | 13,471.4 | 13,471.4 | 10,413.0 | 3,058.4 | 77.3% |
| Зөвлөмж /тоо/ | | 4,499.0 | 4,499.0 | 3,623.8 | 875.1 | 80.5% |
| Нийт дүн | | **18,253.7** | **18,253.7** | **14,189.1** | **4,064.6** | **77.7%** |

Хяналт шалгалтаар илэрсэн нийт зөрчилд өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.



# ЗУРГАА. ДОТООД АУДИТЫН ХОРОО

Аймгийн Засаг даргын 2023 оны А/554 дүгээр захирамжаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх "Дотоод аудитын хороо"-г 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж 2024 онд хорооныүйл ажиллагааг Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу улирал тутамд хуралдуулж дараах асуудлуудыг шийдвэрлүүлэн, хэрэгжилтийн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Үүнд

- 2024 онд давхардсан тоогоор 260 байгууллагад эрсдэлийн үнэлгээнд суурилсан санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг гүйцэтгэхээр төлөвлөн 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөө хуваарийг Дотоод аудитын хороо"-оор батлуулан хэрэгжилтэд хяналт тавин хуваарийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу гүйцэтгэлээ.
- Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны үр дүн,
- Тус албанаас 2024 онд эрсдэлийн үнэлгээнд суурилан боловсруулсан санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын төлөвлөгөө, хуваарийг батлуулах тухай,
- 4. Дотоод аудитын хорооны Нарийн бичгийг томилуулах тухай.
- 5. Албаны бүтэц орон тоог шинэчлэн тогтоох тухай
- Сангийн яамны нэгдсэн удирдамжаар хийгдсэн Гаалийн газрын 2022-2023 оны үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтын дүнгийн тухай
- 17 сумын ХХС-ийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлангийн үр дүнг баталгаажуулах тухай.
- Шилэн дансны тухай хуулийн 2023 оны жилийн эцэс, 2024 оны 1-3 дугаар улирлын хэрэгжилт,
- Хяналт шалгалтын төлөвлөгөөний сүүлийн хагас жилийн хэрэгжилт болон байгууллагын 2024 оны гүйцэтгэлийнхэрэгжилт, зорилтын хүрсэн түвшин болон хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хэрэгжилтийн биелэлтийг тус тус хэлэлцүүлж Дотоод аудитын хорооноос тайлант жилийн хугацаанд нийт хорооны 12 тогтоол гарсан байна.


СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

Дотоод аудитын хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоол "Дүрэм батлах тухай" 4.12, 4.13, Сангийн Сайдын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 29 дүгээр тушаалаар батлагдсан "Дотоод аудитын хорооны дүрэм"-ийн 1.5, 2.1, 2.2, 5.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дотоод аудитын албаны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, түүний дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд явуулсан дотоод аудитын тайланг хэлэлцэн шийдвэрлэх, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаанд зөвлөгөө дэмжлэг үзүүлэх зорилготой аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын хорооны гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай. Үүнд:

Дарга (Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч)

Гишүүд (Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга)
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
(Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга)
(Хууль эрх зүйн хэлтсийн дарга)
(Төрийн бус байгууллагын төлөөлөл)
(Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга (Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор)

2. "Дотоод аудитын хорооны дүрэм"-ийг шинэчлэн батлах тухай Монгол Улсын Сангийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 29 дүгээр тушаалыг мөрдөж ажиллахыг "Дотоод аудитын хороо"-нд даалгасугай.

Н.ЛХАГВАДОРЖ






"Дотоод аудитын хороо"-ны гишүүд хуралд идэвх санаачилгатай оролцож тус албаны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, санхүүгийн хяналт шалгалт, аудитын чанарыг дээшлүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтоолоор баталгаажуулан дэмжлэг үзүүлэн ажилласныг урамшуулж нийт 17,820.0 мянган төгрөгийг батлагдсан төсвийн хүрээнд хорооны гишүүдэд олгосон байна.

# ДОЛОО. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ

Эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, Улсын салбарын дотоод аудитыг хөгжүүлэх зорилтын хэрэгжилтийн хангах чиглэлээр дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ. Үүнд:

- Улсын салбарын дотоод аудитын үйл ажиллагааг орон нутагт чанарын нэгдсэн түвшинд хүргэх, дотоод аудитын чадавхыг бэхжүүлэх, дотоод аудитын бие даасан хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, төрийн үйлчилгээ, үйл ажиллагааны засаглалыг бэхжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор батлагдсан 2023-2025 онд хэрэгжүүлэх "Улсын салбарын дотоод аудитыг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө"-ний хэрэгжилт хангах чиглэлээр Сангийн яамны СХЭУГ болон Сангийн сайдад авч хэрэгжүүлэх арга хэмжээний 5 саналыг боловсруулан хүргүүлсэн.

- Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг шинээр хийж хүний нөөцийн бодлого төлөвлөлтийг сайжруулах, орон тоог нэмэгдүүлэх судалгааны ажлыг гүйцэтгэж саналын хувилбарыг танилцуулж Дотоод аудитын хорооны дэмжлэгтэйгээр аймгийн Засаг даргын А/279 дугаар захирамжаар тус албаны бүтэц орон тоог шинэчлэн батлуулсан.

- Монголын мэргэшсэн дотоод аудиторуудын институттэй хамран 5 албан хаагчийг мэргэшсэн дотоод аудитор бэлтгэх мэргэшүүлэх сургалтад хамрагдаж Сэлэнгэ аймгийн төсөвт байгууллагуудын дундаас анхны Монгол Улсын Мэргэшсэн дотоод аудиторын эрхийг 5 албан хаагч хамгаалсан бол ММНБИ-ийн Аудит баталгаажуулах эрхийг 1 албан хаагч тус тус хамгаалсан байна.

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээний агентлагуудад эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох зорилгоор Сангийн яамнаас улсын салбар дотоод аудитын удирдлагын нэгдсэн системийг нэвтрүүлсэн ба тус систем нь гүйцэтгэсэн санхүүгийн хяналт, шалгалт, дотоод аудитын үр дүнгээр байгууллагын эрсдэлийг бүртгэх дата бааз үүсгэх бүрэн боломжийг бүрдүүлсэн.

**Хүснэгт 9. Бодлогын баримт бичигт тусгагсан зорилт арга хэмжээний хэрэгжилт, 2024 он**

| № | Үндсэн чиглэл, хөтөлбөр | Төлөвлөсөн арга хэмжээний заалтуудын хэрэгжилт |
|---|---|---|
| 1 | Сэлэнгэ аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт | АЗДҮАХ-ийн 3.6.1 дэх хэсэгт тусгагдсан 1 арга хэмжээний хэрэгжилт 100 хувьтай |
| 2 | Сэлэнгэ аймгийн засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт | 10 заалтын хэрэгжилт 100 хувьтай |
| 3 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт | 4 заалтын 100% хэрэгжсэн 4, 100 хувьтай |
| 4 | Монгол Улсын Засгийн газраас зарласан "Авлигатай тэмцэх жил"-ийн хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт | 3 зорилт 5 дэд зорилтын 13 арга хэмжээний хэрэгжүүлэхээс бүрэн хэрэгжсэн 13 хэрэгжилтийн биелэлт 100 хувьтай. |
| 5 | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан | 3 гомдлын шийдвэрлэлт 100 хувьтай |
| 6 | Төрийн байгууллагын нээлттэй ил тод байдлыг хангах | 4 зорилт 23 заалтын хэрэгжилт 100 хувьтай |
| 7 | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 3 бүлэг 8 дэд зорилт 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээс бүрэн хэрэгжсэн 38, дутуу хэрэгжсэн 1 дундаж үнэлгээ 99.5 хувьтай |
| | Нийт | Дундаж үнэлгээ 99.9 хувьтай тайлагнагдсан байна. |

Байгууллагын тасралтгүй ажил үйлчилгээг явуулж байгууллага хамт олноо удирдан чиглүүлж, хувь хүн бүрийн оролцоог жигд хангуулах, багаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ажлын байранд шинэ залуу албан хаагчдыг сургаж дадлагажуулах, туршлага судлуулах ажлыг хийж хамт олныг зохион байгуулж ажилласан.

Аймгийн Засаг даргаас эрхлэх хүрээний агентлагийн дарга нарыг хамруулсан өргөтгөсөн шуурхай хуралдааныг 2024.01.04-ны өдөр зохион байгуулсан ба энэ үеэр байгууллагын үйл ажиллагааны товч тайланг танилцуулсан.

Аймгийн Засаг даргын өргөтгөсөн шуурхай хуралдаанаар 2024 онд өвөлжилт хүндэрч байгаатай холбогдуулан аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагийн удирдлагууд цаг үеийн шуурхай мэдээллийг өгч Засаг даргаас цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар үүрэг чиглэлийг өгснийг хэрэгжүүлэн ажилласан.

Аймгийн Засаг даргаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу МУЗГ-ын гишүүдтэй 2024 онд хамтран ажиллах гэрээнд тусгах арга хэмжээ саналыг боловсруулан хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2024 онд хэрэгжүүлэх бодлого, чиглэлийн уялдааг ханган боловсруулж батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан.







Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөлд тус албанаас дараах 2 зорилт 4 арга хэмжээний саналыг боловсруулж хүргүүлэв. Үүнд:

**Зорилт 1**.Дотоод аудитын 2025-2028 оны дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулж түүнд суурилсан Дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулна.

*Дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангана.*

*Хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулахад шаардлагатай тээврийн хэрэгслийг шийдвэрлүүлэх*

**Зорилт 2**. Дотоод аудитын нэгж байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлэх, журмыг боловсруулж батлуулж хэрэгжилтэд хяналт тавина

*Дотоод аудитор, санхүүгийн улсын байцаагч нарын тасралтгүй сургалтыг зохион байгуулж мэргэшүүлэх*

*ТЕЗ-ийн дотоод үйл ажиллагааны эрсдэл үнэлэх журмыг боловсруулан батлуулах гэсэн 4 арга хэмжээний саналыг боловсруулан хүргүүлэв.*

# НАЙМ. ДОТООД АЖИЛ

## 8.1 АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТ:

2024 онд ирсэн бичиг 181, явсан бичиг 134 бүртгэгдэж, даргын "А" тушаал 18, "Б" тушаал 20 тус тус гарсан ба аудитын тайлан-16, санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэл 25 улсын байцаагчийн акт 19, албан шаардлага 126, тайлан дүнг хянан хэлэлцэх, албан хаагчдыг шагналд тодорхойлох чиглэлээр удирдлагын зөвлөлийн нийт 9 хурал хийгдсэнийг хурлын тэмдэглэлээр баталгаажуулсан байна.

**Хүснэгт 10. Баримт бичгийн бүртгэл**

| № | Баримт бичгийн төрөл | Нийт |
|---|---|---|
| 1 | Ирсэн бичиг Явсан бичиг | 316 |
| 2 | Даргын "А" тушаал | 18 |
| 3 | Даргын "Б" тушаал | 20 |
| 4 | Хурлын тэмдэглэл | 9 |
| 5 | Төлбөрийн акт | 19 |
| 6 | Албан шаардлага | 126 |
| 7 | Хяналт шалгалтын тэмдэглэл | 25 |
| 8 | Аудитын тайлан, дүгнэлт | 13 |

Албан хаагчид ХХНЖ-ын дагуу тайлант онд үүсэж хөтлөгдсөн баримт материалыг ангилан төрөлжүүлж, байгууллагын архивд нийт 22 баримт материалыг шилжүүлсэн бөгөөд 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу бүрэн хөтлөгдөж дууссан аудитын тайлан, ажлын баримтуудыг зохих стандартын дагуу үдэж хавтасласан эсэхэд хяналт тавьж, цаасан суурьтайгаар хүлээн авч, хадгаламжийн нэгжийн дугаар үүсгэн, бүртгэж хүлээн авсан.

Зураг 3. **Архивын баримтын тоо бүртгэл**




2024 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын архивд нийт 223 хадгаламжийн нэгж бүртгэлтэй байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэй холбоотойгоор тус албанд эхний хагас жилийн байдлаар 3 гомдол ирснээс аймгийн Засаг даргаас Цант-Орхон ОНӨААТҮГ-ын удирдлагатай холбоотой гаргасан гомдол гаргагчийн нэр, хаяггүй тул хянан үзэх боломжгүй үндэслэлээр буцааж Мандал сумын Хэрх тосгоны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд иргэд, ААНБ-ын хандивын хөрөнгийн зарцуулалт, Сайхан сумын Хот тохижилтын газрын байгууллагын удирдлагын үйл ажиллагаа, төсөв, санхүү, өмч хөрөнгийн ашиглалт хадгалалт хамгаалалт, зарцуулалт, үндэслэлгүй ажлаас халсан гэх асуудлаар гаргасан гомдлын бүртгэлд авч хяналт шалгалтыг явуулж үзэж хуулийн хугацаанд хариуг хүргүүлэн олон нийтэд мэдээлж ажилласан.

Тус хяналт шалгалтаар нийт 361,137.8 мянган төгрөгийн санхүүгийн зөрчил илэрснийг санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд 5,859.9 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 275,277.9 мянган төгрөгийн 4 зөрчилд зөрчлийг таслан зогсоох албан шаардлага, 80,000.0 мянган төгрөгийн 9 зөрчилд цаашид дахин давтан гаргахгүй байх зөвлөмжийг тус тус өгч шийдвэрлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

АТГ-аас харьяаллын дагуу аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний байгууллагад шилжүүлсэн иргэний гомдлыг шийдвэрлүүлэхээр манай албанд өгсөн үүргийн хэрэгжилтийг ханган хуулийн хугацаанд үр дүнг хүргүүлэн ажилласан.

## 8.2 АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ:

Монгол Улсын Засгийн газраас зарласан "Авлигтай тэмцэх жил"-ийн хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 5 дэд зорилт 11 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэн ажиллаа.

Тайлант хугацаанд АТГ-аас гаргасан болон өөрсдийн боловсруулсан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 10 гаруй сурталчилгааны материал, мэдээллийг байршуулж, сар бүр шинэчилж байна, Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн авлигын эсрэг 12 орчим сурталчилгааны постер, reel, видео шторк, зурагт хуудас, мэдээлэл зэргийг "Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны " фэйсбүүк хуудсаар дамжуулан Сэлэнгэ аймгийн зарын группууд, 17 сумын ЗДТГ-ын фейсбүүк хуудас, Харилцагч байгууллагуудын группүүдэд түгээх байдлаар авлигын эсрэг сурталчилгааг иргэд, олон нийтэд хүргэсэн, Албан тушаалтнууд Санхүүгийн хяналт шалгалт, аудит хийх бүрдээ "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл" -ийг хөтлөн, "Нөлөөллийн мэдүүлэг"-ийн талаар шалгагдагч байгууллагад танилцуулж, баталгаажуулж хэвшсэн бөгөөд 2024 онд нийт 37 нөлөөллийн мэдүүлгийн танилцуулсан байна, ХАСХОМ мэдүүлэх 5 албан хаагчийн мэдүүлгийг 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор баталгааны хуудсаар хүлээн авч, цахимаар хянаж баталгаажуулсан гэх мэт.









Байгууллагын мэдээллийн ил тод байдал, төрийн үйлчилгээг цахимжуулах, мэдээллийн сувгийн нэмэгдүүлэх ажлын хүрээнд албан ёсны цахим хуудсыг "Би Би Эс Софт" ХХК-тай хамтран ажиллах гэрээний дагуу веб бүтээх үйлчилгээг гүйцэтгүүлж төрийн байгууллагын ил тод байдлыг цахимжуулах үе шаттай ажлуудыг байгууллагын цахим хуудас болон shilendans.gov.mn. shilen.gov.mn, Facebook цахим хуудсуудад мэдээллийг байршуулж байна.














Тайлант жилийн хугацаанд Сангийн яамнаас нэвтрүүлж байгаа хяналт шалгалтын аудитын удирдлагын нэгдсэн систем, Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн "ERP"систем,Төрийн сангийн удирдлагын нэгдсэн систем, Хүний нөөцийн удирдлагын нэгдсэн системүүдийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж хэвшүүлсэн байна.

Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг ханган 2024 онд хийж гүйцэтгэсэн нийт 41 хяналт шалгалтын тайланг https://sankhuuaudit.se.gov.mn/сайтад байршуулсан байна. Тус газраас 2024 онд хийж гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар товч танилцуулга бэлтгэн "Сэлэнгийн мэдээ" сонинд нийтлүүлсэн бол 5 аудитын тайлангаар инфографик бэлтгэн өөрийн байгууллагын Facebook хуудсаар болон open.audit.mn сайтаар нийтэд түгээсэн, 2023 онд тус газрын үйл ажиллагаанд 617.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 594.7 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, урьдчилсан байдлаар 96.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдахаар байгаа бөгөөд цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 22.9 сая төгрөгөөр, бусад зардлууд 0.2 сая төгрөгөөр тус тус хэмнэгдэхээр байна. Төсвийн ил тод байдлыг хангаж шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 151 мэдээллийг бүрэн мэдээлсэн.

Байгууллагын 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг дэмжих дотоод ажлын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

**Зохион байгуулсан сургалтууд, 2024**




Тайлант онд Төрийн албаны зөвлөлөөс 19 цахим сургалт, байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу 10 сургалт, бусад байгууллагаас 6 сургалт тус тус зохион байгуулагдаж, давхардсан тоогоор нийт 350 албан хаагчдыг хамруулсан байна. Тус сургалтуудаас онцлох сургалтуудыг түүвэрлэж оруулав. Үүнд:

**Бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтууд:**

Сангийн яам, Дархан-Уул аймагтай хамтран төвийн бүсийн сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 27-ноос 05 дугаар сарын 28-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн байгууллагын дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчдыг чадавхжуулах сургалтад тус байгууллагын нийт албан хаагчдыг хамруулсан.








Монголын мэргэшсэн дотоод аудиторуудын институттэй хамран 5 албан хаагчийг мэргэшсэн дотоод аудитор бэлтгэх мэргэшүүлэх сургалтад хамрагдаж Сэлэнгэ аймгийн төсөвт байгууллагуудын дундаас анхны Монгол Улсын Мэргэшсэн дотоод аудиторын эрхийг 5 албан хаагч хамгаалсан бол ММНБИ-ийн Аудит баталгаажуулах эрхийг 1 албан хаагч тус тус хамгаалсан байна.





Хангайн бүсийн аймгуудын нягтлан бодогч, санхүүч, эдийн засгийн ажилтны сургалт зөвлөгөөнийг Орхон аймгийн ЗДТГ, Эрдэнэт үйлдвэр, ММНБИ-ийн хамтран зохион байгуулсан сургалтад тус албанаас 2 мэргэшсэн нягтлан бодогч хамрагдсан ба тухайн арга хэмжээтэй давхцуулан Аймгийн Засаг даргын орлогчийн 2024 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 04 дугаар удирдамжаар батлагдсан Дархан-Уул, Орхон аймгуудын Санхүүгийн хяналт, дотоод аудитын албатай хамтран ажиллаж тус албадын үйл ажиллагаа, бүтэц орон тоо, хүний нөөц бодлого төлөвлөлттэй танилцаж мэдээлэл солилцож Дархан-Уул, Орхон аймгийн хувьд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын баримтууд, акт албан шаардлага болон, мэдээллийн системийн нэвтрэлт хөгжүүлэлттэй танилцан тухайн байгууллагуудаас шинэлэг санаа аван үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд хамтын оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээнд тус албаны 5 албан хаагчийг тус тус хамруулсан.








**Өөрийн сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан сургалт:**

Байгууллагын 2024 оны "Мэргэшлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөө"-ний хүрээнд дараах сургалтуудыг зохион байгуулж, давхардсан тоогоор 60 албан хаагч хамрагдлаа. Үүнд:

- Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлж байсан алдаа, зөрчил түүний шийдвэрлэлт, тайлант оны хяналт шалгалтыг төлөвлөхөд эрдэлийн үнэлгээ хийх арга зүй
- Төрийн албаны цалингийн нэгдсэн систем, түүнийг хяналт шалгалтад ашиглах нь,
- 2024 онд шинээр батлагдсан хууль, Засгийн газрын тогтоол, шийдвэр, захиргааны хэм хэмжээний акт
- Санхүүгийн хяналт шалгалт, аудитын тайлан дүнг олон нийтэд цахимаар хүргэх арга зам, инфографик, видео шторк ашиглаж мэдээлэл бэлтгэх
- 2024 онд дэвшүүлсэн "Дотоод аудитын чанарын үр нөлөөг сайжруулах
- Дотоод аудитын процесс,
- Санхүүгийн хяналт шалгалтын процесс
- Үр дүнд суурилсан төсөвлөлт, түүнд хяналт тавих арга зүй
- Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр дүн тооцох
- ХАСХОМ-ийг мэдүүлэх,
- Авлигатай тэмцэх хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, цаашид анхаарах асуудлууд зэрэг сэдвүүдээр төлөвлөгөөнд тусгагдсан сургалтуудыг зохион байгуулсан.







/ Албан хаагчид дотоод сургалтад хамрагдаж байгаа нь /

Тус албанаас 2024 оны орон нутгийн сонгуулийн үр дүнд шинээр сонгогдсон Түшиг, Сүхбаатар сумын ИТХ-ийн төлөөлөгчдөд "Үр дүнд суурилсан төсөвлөлт" сэдвээр сургалт зохион байгуулж санхүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад цаашид анхаарах чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.





Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас төрийн салбар бүрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтрсан Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн болон ОНӨААТҮГ-ын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарыг хамруулсан 140 албан хаагч оролцсон нэгдсэн сургалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулсан.





## ШАГНАЛ УРАМШУУЛАЛ, ШИНЭ САНААЧИЛГА, САХИЛГЫН ШИЙТГЭЛ

Ардын хувьсгалын 103 жилийн ойг тохиолдуулан тус албаны ахлах дотоод аудитор СХШУБ Т.Мөнхзул "Алтан гадас", одонгоор албаны дарга СХШУАБ Т.Одсүрэн "Хөдөлмөрийн хүндэт медаль"-иар тус тус шагнагдсан бол Орон нутагт Улсын салбарын дотоод аудитын албан үүсэн байгуулагдсан 10 жилийн ойгоор дотоод аудитор Ц.Уртнасан, Х.Батбаатар нар "Санхүү банкны тэргүүний ажилтан" цол тэмдэгээр, аймгийн ИТХ-ийн "Хүндэт өргөмжлөл"-өөр, дотоод аудитор Г.Дорждэрэм, "Хүндэт иргэн" тэмдгээр ахмад ажилтан Д.Нарантуяа, Аймгийн Засаг даргын шагналаар ахмад ажилтан Б.Дарихжав, Сүхбаатар сумын Засаг даргын "Хүндэт жуух" бичгээр Ерөнхий нягтлан бодогч, М.Анударь, Архив бичиг хэргийн ажилтан Б.Ууганзаяа нар тус тус шагнагдсан байна.





2024 онд 6 төрийн жинхэнэ албан хаагчтай" Гүйцэтгэлийн төлөвлөгөө", төрийн үйлчилгээний 3 албан хаагчтай "Хөдөлмөрийн гэрээ" байгуулан, улирлаар дүгнэж байгаа бөгөөд жилийн эцсийн байдлаар үр дүнгийн мөнгөн урамшуулалд нийт 18.2 сая төгрөг олгосон байна.











Тайлант онд сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагч байхгүй болно.

# ЕС.ТӨСӨВ САНХҮҮ, ГҮЙЦЭТГЭЛ

2024 онд тус албаны үйл ажиллагаанд 456.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 394.2 сая төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 86.3 хувьтай буюу 13.7 хувиар хэмнэгдсэн байна. Үүнээс цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 27.5 сая төгрөгөөр, Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 4.4 сая төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардлыг 7.1 сая төгрөгөөр, Эд хогшил, урсгал засварын зардлыг 1.8 сая төгрөгөөр, томилолтын зардлыг 5.3 сая төгрөгөөр , бусад зардлыг 16.2 сая төгрөгөөр тус тус хэмнэж, төсвийн авлага, өр төлбөргүй тайлагнагдаж байна.







Төсвийн тайлант хугацаанд батлагдсан хүрээнд 5.4 сая төгрөгийн шатахуун, 2.7 сая төгрөгийн бичиг хэргийн материал, 18.2 сая төгрөгийн компьютер, техник хэрэгсэл, 6.9 сая төгрөгийн тавилга эд хогшил, 11.5 сая төгрөгийн урсгал засвар зэрэг шууд худалдан авах босго үнэд багтсан худалдан авах ажиллагааг гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу хагас, бүтэн жилээр гарган, тайлагнаж байгаа ба 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "Төрийн аудитын байгууллага" санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэсэн ба аудитаар "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт авсан болно.

НДШ-ийн тайланг сар сүр, ХХОАТ-ын тайланг улирлаар гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэн, Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн Burtgel.pcsp.gov.mn цахим сайтад хөрөнгийн эхний, эцсийн үлдэгдэл, хөдлөл өөрчлөлтийн мэдээ, санхүүгийн тайланг бүрэн шивж оруулсан байна.

2023 оны үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, санхүүгийн тайлан болон 2024 оны төсвийн төслийг боловсруулж, тогтоосон хугацаанд нь СТСХ хүргүүллээ.

Байгууллагын даргын тушаалаар томилогдсон тооллогын комисс хагас, бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд нь хийж гүйцэтгэн Өмч хамгаалах зөвлөлийн хурлаар баталгаажуулан, 2022 оны жилийн эцсийн тооллогоор дүнгээр үндсэн хөрөнгийн ашиглалтын жил дууссан цаашид ашиглах нь эдийн засгийн хувд үр ашиггүй болсон 7 нэр төрлийн 14 ширхэг 9,820.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлуулах санал хүргүүлснийг аймгийн ИТХ-ын 2024 оны 04-р сарын 02-ны өдрийн 158 дугаар тогтоолоор данснаас хасаж актлах шийдвэр олгосны дагуу Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж үндсэн хөрөнгийн данс бүртгэлээс хасаж устгалын акт үйлдэн хурлын тэмдэглэлээр баталгаажуулан тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан тайлан, холбогдох санхүүгийн баримтуудыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт албан бичгээр хүргүүлсэн. аймгийн Орон нутгийн өмчийн газартай 2022 онд байгуулсан төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг 95.0 хувьтай дүгнүүлж , төрийн өмчийг эзэмшүүлэх 2024 оны гэрээг сунгасан байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2024 оны А/60 тоот захирамжийн дагуу төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх зорилгоор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагаанд 15.6 сая төгрөгийн иж бүрэн суурин компьютер 4 ширхэг, 3 үйлдэлтэй хэвлэгч төхөөрөмж 3 ширхэг тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлснийг бүртгэл тайланд тусган нотлох баримтыг хөрөнгө хүлээн авсан актын хамт ЗДТГ-ын санхүүд хүлээлгэн өгсөн.



# АРАВ.ДҮГНЭЛТ

Санхүүгийн хяналт дотоод аудитын алба нь 2024 оны "Санхүүгийн хяналт, дотоод аудитын чанарын үр нөлөөг сайжруулах" үндсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа чиглүүлэн, "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан 3 бүлэг 8 дэд зорилт 39 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2024 онд хийж гүйцэтгэсэн хяналт шалгалтаар нийт 340 төрлийн 18,253.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 283.4 сая төгрөгийн 20 төлбөрийн акт тогтоон, цаашид зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 13,474.4 сая төгрөгийн 126 албан шаардлага, 4,499.0 сая төгрөгийн 163 зөвлөмж хүргүүлснээс төлбөрийн акт 53.7 хувьтай, албан шаардлага 77.5 хувьтай, зөвлөмжийн хэрэгжилт 80.5 хувьтай тайлагнагдсан байна.

Тус албаны 2024 оны үйл ажиллагаанд 456.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 394.2 сая төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 86.3 хувьтай буюу 13.7 хувиар хэмнэгдсэн байна. Үүнээс цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 27.5 сая төгрөгөөр, Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 4.4 сая төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардлыг 7.1 сая төгрөгөөр, Эд хогшил, урсгал засварын зардлыг 1.8 сая төгрөгөөр, томилолтын зардлыг 5.3 сая төгрөгөөр , бусад зардлыг 16.2 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

2024 онд нийт 183 обьект үүнээс 17 сан, 166 байгууллагын үйл ажиллагаанд аудит болон санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэснээс шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар 128 байгууллагыг улирал тутам хяналт тавин ажиллаж, 25 Төсвийн шууд захирагчид санхүүгийн хяналт шалгалт, 9 Төсвийн төвлөрүүлэн захирагч, 4 ОНӨААТҮГ-т дотоод аудит 17 сумын Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА Т.ОДСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ ДОТООД АУДИТОР Т.МӨНХЗУЛ